

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 3 2021 оны 12-р сар

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХУЙЦ НӨХӨН СЭРГЭЭЛТ, ХААЛТЫН МЕНЕЖМЕНТ

R. L. Нобле-Паттинсон, M.E.Des., EP

Уур амьсгалын өөрчлөлт манай гаригийн хүн бүрийн өдөр тутмын аж амьдралд аль хэдийн нөлөөлөх болсон. Уурхайн компаниуд, Засгийн газрууд, эрдэмтэн судлаачид эдийн засгийн салбар бүрийг уур амьсгалын өөрчлөлт гэсэн линзээр харах шаардлагатай болжээ. Уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментэд байгаль орчин, хүн амын эрүүл, аюулгүй байдлыг хангахын тулд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зарчмыг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Энэ удаагийн мэдээнд Монгол оронд нүүрлэж буй уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллүүд болон уурхайн хаалтад үзүүлэх эрсдэлийг бууруулах сайн туршлагын талаар танилцуулж байна.

2021 ОНЫ ДЭЛХИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ ХУРАЛ

Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцийн талуудын 26 дугаар бага хурал (COP26) 2021 оны 11-р сарын эхээр Их Британийн Глазго хотод болж өнгөрлөө. Дэлхийн удирдагчид, улс төрчид, дипломатууд, эрдэмтэд, шийдвэр гаргагчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүд, бусад төлөөлөгчид дараагийн арван жилд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах талаар ямар шийдвэр гаргаж буйг дэлхий дахин анхааралтай ажиглаж байв. Эрдэмтэн судлаачид дэлхийн дулаарлын индексийг 1.5C тогтоон барих, “цаг агаарын сүйрэл”-ээс сэргийлэхийн тулд нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг бууруулах дорвитой арга хэмжээ авах ёстойг онцлов. Түүнчлэн малтмал түлшний эрчим хүч үйлдвэрлэлийг хязгаарлах, хөгжиж буй орнуудад тусламж үзүүлэх, метан хийн ялгарлыг бууруулах, ой мод огтлохыг зогсоох зэргийг хэлэлцэж, санал нэгдэв (BBC, 2021). Эдгээр зорилтод хүрэхийн тулд уул уурхайн салбар чухал үүрэг гүйцэтгэх болно.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА УУРХАЙН ХААЛТ

Уурхайн ашиглалт байгалийн унаган төрхийг өөрчилдөг учир гадаргуугийн хэлбэр дизайн, хог хаягдлын менежмент, нөхөн сэргээлт гэх мэт байгаль орчны олон асуудлыг оновчтой төлөвлөж, шийдвэрлэх хэрэгтэй болдог. Уурхайн үүсмэл гадаргуу буюу хаягдлын байгууламжийг геотехникийн тогтворжилтийн стандартад нийцүүлэх, ус зайлуулалтын систем, газар ашиглалтын зорилго (хөдөө аж ахуй, цэцэрлэгт хүрээлэн, ой мод, зэрлэг амьтны идээшил, амралт зугаалга)-д нийцсэн нөхөн сэргээлт буюу байгалийн төрхөд дөхүүлсэн хөрс, ургамал бий болгохыг өнөөгийн сайн туршлага, эрх зүйн орчин уурхайн компаниудаас шаарддаг болсон. Дэлхийн дулаарлын нөлөөллөөр үер ус, салхи шуурга гэх мэт цаг агаарын гамшигт үзэгдлүүдийн давтамж нэмэгдэж буй нь хүн төрөлхтөн, зэрлэг амьтдад улам ихээр эрсдэл учруулж, дэд бүтцийг сүйрүүлэн, эдийн засгийн хохирол учруулж байна. Судлаачид болон шийдвэр гаргагчидын хувьд нөхөн сэргээлтийн геотехникийн тогтворшилийг хангах, хаягдал материалыг шийдвэрлэх, цаг агаарын эрсдэлд тэсвэртэй нөхөн сэргээлтийн үр дүнг бий болгох шинжлэх ухааны ололт, сайн туршлага ихээхэн чухал асуудал болоод байна.

ДЭЛХИЙН ДУЛААРЛ МОНГОЛ УЛСАД

Монгол улсын математик загварчлалаар тооцоолсон цаг агаарын мэдээлэл нь уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын дата санд хадгалагддаг. Дэлхийн дулаарлаас үүдэлтэй цаг агаарын янз бүрийн үзэгдлүүд эдийн засагт хэрхэн нөлөөлөх үр дагаварыг урьдчилан тооцоолж болдог.

Далайд гарцгүй Монгол улс нь агаарын температурын хэлбэлзэл ихтэй, хур танадас бага хуурай цаг агаартай. Монгол орны агаарын жилийн дундаж температур 1940 оноос 2008 оны хооронд 2.140C-ээр нэмэгдсэн нь дулаарал илүү эрчимтэй явагдаж байгаагийн илрэл юм. Шороон шуургатай өдрийн тоо 1960 онд 18 байсан бол 2008 онд 57 болж нэмэгдсэн нь уур амьсгалын өөрчлөлтийг илтгэж байна.

Түүнчлэн цаг агаарын ноцтой үзэгдэл болох ган, зудын давтамж нэмэгдсэн нь байгаль орчин, эдийн засаг, нийгэмд ихээхэн нөлөө учруулж байна. Нийт нутаг дэвсгэрийн 70% нь цөлжилтэд өртөж, ургамлын биомасс 20-30% буурч, гол горхи, нуурууд олноор ширгэж байна (БОАЖЯ). Монгол улсын газар зүйн байршил, эмзэг экосистем, байгаль, цаг агаараас хараат бэлчээрийн мал аж ахуй ба газар тариалан зэрэг голлох салбаруудаасаа шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий орнуудын тоонд орж, улс орны эдийн засаг, ард түмний амьдралын түвшинд таагүй нөлөө үзүүлэх хэмжээнд нэгэнт хүржээ (Дэлхийн банк & Азийн хөгжлийн банк, 2021). Монгол улсын Засгийн газар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх суурь конвенцид нэгдэн, COP26 арга хэмжээд идэвхтэй оролцсон бөгөөд, “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (2011-2021)” ба “Ногоон хөгжлийн бодлого (2014-2030)”-ыг батлан хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад анхааран ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Талуудын 26 дугаар бага хуралд оролцохдоо “Уур амьсгалын өөрчлөлтөд ихээр өртөж буй орнуудын нэг болох Монгол Улс хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн чармайлтыг бүрэн дэмжиж, Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхийн төлөө бүх боломж, нөхцөлөө дайчлан ажиллах болно” гэдгээ илэрхийлсэн (UNFCCC, 2021).

Эх сурвалж: <http://g-bilguun.blogspot.com/>



Монгол оронд нүүрлэж буй цөлжилт

Эх сурвалж: <http://npost.mn/>



Мандалговь хотод болсон шороон шуурга

■ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ МЕНЕЖМЕНТ БҮХИЙ ХААЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уурхайн хаалтын менежмент, нөхөн сэргээлтийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ хийх бүх үе шатанд цаг агаарын аюул, эрсдэлүүдийг тооцоолох, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежмент хэрэгжүүлэх нь нэн чухал.

Уул уурхайн байгууллагууд дэлхийн дулаарлын эсрэг, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон менежмент хэрэгжүүлэх бодлого баримталж байна. Тухайлбал: Олон улсын уул уурхай, металлургийн зөвлөлөөс Парисын хэлэлцээр болон НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд эрдэс баялгийн салбар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэлд хувь нэмрээ оруулахад гишүүн байгууллагууд нь хүчин зүтгэл гаргаж ажиллахаа мэдэгдсэн (ICMM, 2021a).

Канадын уул уурхайн ассоциаци “Тогтвортой уул уурхайн санаачлага” хэрэгжүүлж, гишүүн компаниуд нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах техник, технологийн инновац нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулахаа илэрхийлсэн (MAC, 2021).

Монголын уул уурхайн үндэсний ассоциаци “Хариуцлагатай уурхайн кодекс” санаачлага хэрэгжүүлж, гишүүн компаниудын байгаль орчин, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийн манлайллыг бэхжүүлэн ажиллаж буй ажээ.

Олон улсын уул уурхай, металлургийн зөвлөл (ОУУУМЗ)-өөс уур амьсгалын өөрчлөлтөөс уул уурхайн салбарт учруулж буй эрсдэлүүдийг тодорхойлж, дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг сайжруулах тухай “Уул уурхайн өөрчлөлтөд дасан зохицох: Уул уурхайн ба металлургийн үйлдвэрлэлийн чадамж” гарын авлага хэвлүүлжээ (ICMM, 2021b). Түүнчлэн тус байгууллага “Уурхайн хаалтын тэргүүн туршлага” гарын авлагадаа төсөл хэрэгжүүлэгчид хаалтын төлөвлөлт хийхэд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн тухай “Уур амьсгалын өөрчлөлт: Боломж ба бэрхшээлийг удирдах нь” аргачлалыг оруулсан.

Эх сурвалж: <http://erdenessilver.mn/>



Салхитын уурхай



Говийн бүсэд хөрс хуулалт эхлүүлж буй